



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор Д.Эрдэнэбулган Утас: 89818085 Цахим хаяг: erdenebulganda@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.24 № 2/24
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020196

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,541,214.00</u>	<u>34,943,414.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	15,480,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	15,480,000.00
3121	Төгрөг	00.00	15,480,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	15,480,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,541,214.00	19,463,414.00
354	Хангамжийн материал	14,541,214.00	19,463,414.00
35410	Бичиг хэргийн материал	1,397,790.00	2,479,790.00
35420	Аж ахуйн материал	13,143,424.00	16,983,624.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,466,291,642.57</u>	<u>2,440,488,170.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,466,291,642.57	2,440,488,170.16
392	Биет хөрөнгө	1,410,766,642.57	2,384,963,170.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,482,880,189.00	2,498,898,626.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-146,669,391.51	-267,497,841.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,998,000.00	49,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,998,000.00	-49,998,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,454,003.24	224,917,007.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-69,049,348.33	-95,471,453.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,662,137.40	159,502,137.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-121,510,947.23	-135,385,305.89
393	Биет бус хөрөнгө	55,525,000.00	55,525,000.00
39301	Програм хангамж	8,105,000.00	8,105,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,105,000.00	-8,105,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	55,525,000.00	55,525,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,480,832,856.57</u>	<u>2,475,431,584.16</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,480,832,856.57</u>	<u>2,475,431,584.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,480,832,856.57	2,475,431,584.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,454,481,459.57	1,454,481,459.57
51101	Өмч: - төрийн	1,454,481,459.57	1,454,481,459.57
512	Хуримтлагдсан үр дүн	-17,629,167.57	976,969,560.02
51210	Өмнөх үеийн үр дүн	-17,629,167.57	-17,629,167.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	994,598,727.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,980,564.57	43,980,564.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,480,832,856.57</u>	<u>2,475,431,584.16</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,774,453,182.38	3,477,875,891.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,312,835,722.38	1,051,238,733.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,312,835,722.38	1,051,238,733.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	15,480,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	15,480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,461,617,460.00	2,426,637,158.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,360,843,600.00	2,160,839,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,360,843,600.00	2,160,839,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,773,860.00	265,797,258.20
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	197,402,786.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,248,860.00	67,904,472.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	490,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,510,175,687.73	2,483,277,163.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,510,175,687.73	2,483,277,163.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,486,122,865.44	2,249,202,242.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,118,559,179.40	1,648,386,810.50
210101	Үндсэн цалин	630,445,785.82	810,123,695.87
210102	Нэмэгдэл	294,363,280.08	496,722,575.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,590,632.00	224,642,860.73
210104	Урамшуулал	93,159,481.50	116,897,678.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,795,400.00	205,762,647.00
210201	Тэтгэврийн даатгал	97,140,900.00	141,745,047.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,663,600.00	16,004,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,530,900.00	8,002,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,132,700.00	8,002,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,327,300.00	32,008,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,851,914.03	87,377,535.14
210301	Гэрэл, цахилгаан	5,771,977.03	5,882,856.64
210302	Түлш, халаалт	57,563,355.00	73,400,888.50
210303	Цэвэр, бохир ус	2,516,582.00	8,093,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,791,176.28	12,998,712.94
210401	Бичиг хэрэг	3,153,560.00	5,018,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,178,060.00	4,485,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,497,356.28	1,273,197.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962,200.00	2,221,590.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,019,100.00	2,835,000.00
210604	Урсгал засвар	3,019,100.00	2,835,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	5,943,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	5,943,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,097,678.00	209,747,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,458,118.00	208,218,572.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	535,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	901,200.00
210807	Газрын төлбөр	317,660.00	317,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,008,417.73	76,150,605.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,434,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,574,417.73	76,150,605.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,052,822.29	234,074,920.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,581,218.00	234,012,739.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,111,218.00	21,324,839.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	210,927,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,000.00	1,760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,471,604.29	62,181.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,471,604.29	62,181.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,264,277,494.65	994,598,727.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,264,277,494.65	994,598,727.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,461,617,460.00	2,442,117,158.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	15,480,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	15,480,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	15,480,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	15,480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,461,617,460.00	2,426,637,158.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,360,843,600.00	2,160,839,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,360,843,600.00	2,160,839,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,773,860.00	265,797,258.20
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	197,402,786.20

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,248,860.00	67,904,472.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	490,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,460,457,460.00	2,412,048,758.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,460,457,460.00	2,412,048,758.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,404,637.71	2,177,973,837.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,118,559,179.40	1,648,386,810.50
210101	Үндсэн цалин	630,445,785.82	810,123,695.87
210102	Нэмэгдэл	294,363,280.08	496,722,575.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,590,632.00	224,642,860.73
210104	Урамшуулал	93,159,481.50	116,897,678.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,795,400.00	205,762,647.00
210201	Тэтгэврийн даатгал	97,140,900.00	141,745,047.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,663,600.00	16,004,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,530,900.00	8,002,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,132,700.00	8,002,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,327,300.00	32,008,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,851,914.03	87,377,535.14
210301	Гэрэл, цахилгаан	5,771,977.03	5,882,856.64
210302	Түлш, халаалт	57,563,355.00	73,400,888.50
210303	Цэвэр, бохир ус	2,516,582.00	8,093,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,075,966.28	14,052,712.94
210401	Бичиг хэрэг	3,438,350.00	6,072,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,178,060.00	4,485,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,497,356.28	1,273,197.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962,200.00	2,221,590.00
2105	Нормативт зардал	59,000.00	908,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,000.00	908,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,019,100.00	4,665,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,650,000.00
210604	Урсгал засвар	3,019,100.00	3,015,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	5,943,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	5,943,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,610,078.00	210,877,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,138,118.00	209,455,472.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	535,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	77,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,305,400.00	794,000.00
210807	Газрын төлбөр	317,660.00	317,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,434,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,434,000.00	00.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,052,822.29	234,074,920.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,581,218.00	234,012,739.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,111,218.00	21,324,839.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	210,927,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,000.00	1,760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,471,604.29	62,181.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,471,604.29	62,181.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,160,000.00	30,068,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,160,000.00	14,588,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,160,000.00	14,588,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,160,000.00	14,588,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,160,000.00	14,588,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,160,000.00	-14,588,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	15,480,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	15,480,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,281,906,662.22	00.00	216,555,361.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,281,906,662.22	00.00	216,555,361.92
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,264,277,494.65	00.00	1,264,277,494.65
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-17,629,167.57	00.00	1,480,832,856.57
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-17,629,167.57	00.00	1,480,832,856.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-17,629,167.57	00.00	1,480,832,856.57
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	994,598,727.59	00.00	994,598,727.59
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	976,969,560.02	00.00	2,475,431,584.16



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,160,839,900.00	2,160,777,718.38	62,181.62	99.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,160,839,900.00	2,160,777,718.38	62,181.62	99.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,926,821,700.00	1,926,764,979.38	56,720.62	99.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,599,647,600.00	1,599,643,871.30	3,728.70	100.00
210101	Үндсэн цалин	840,126,500.00	810,123,695.87	30,002,804.13	96.40
210102	Нэмэгдэл	511,779,900.00	447,979,636.17	63,800,263.83	87.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	150,503,200.00	224,642,860.73	74,139,660.73	- 1.49
210104	Урамшуулал	97,238,000.00	116,897,678.53	19,659,678.53	- 1.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,102,800.00	201,102,800.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	137,085,200.00	137,085,200.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,004,300.00	16,004,300.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,002,200.00	8,002,200.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,002,300.00	8,002,300.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,008,800.00	32,008,800.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,389,900.00	87,377,535.14	12,364.86	99.90
210301	Гэрэл, цахилгаан	5,886,500.00	5,882,856.64	3,643.36	99.90
210302	Түлш, халаалт	73,401,000.00	73,400,888.50	111.50	100.00
210303	Цэвэр, бохир ус	8,102,400.00	8,093,790.00	8,610.00	99.80
2104	Хангамж, бараа материалын зардал	14,056,900.00	14,052,712.94	4,187.06	100.00
210401	Бичиг хэрэг	4,862,000.00	6,072,000.00	-1,210,000.00	1.25
210402	Тээвэр, шатахуун	4,869,000.00	4,485,925.00	383,075.00	92.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	740,200.00	1,273,197.94	-532,997.94	1.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,530,600.00	2,221,590.00	1,309,010.00	62.90
2105	Нормативт зардал	908,500.00	908,500.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	908,500.00	908,500.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,326,200.00	16,314,400.00	11,800.00	99.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,657,500.00	11,649,400.00	8,100.00	99.90

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,650,000.00	1,650,000.00	0.00	1.00
210604	Урсгал засвар	3,018,700.00	3,015,000.00	3,700.00	99.80
2107	Томилолт, зочны зардал	5,943,000.00	5,943,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	5,943,000.00	5,943,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,446,800.00	1,422,160.00	24,640.00	98.20
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,100.00	77,500.00	600.00	99.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	56,300.00	33,000.00	23,300.00	58.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	794,400.00	794,000.00	400.00	99.90
210807	Газрын төлбөр	318,000.00	317,660.00	340.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234018200.00	234012739.00	5,461.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,018,200.00	234,012,739.00	5,461.00	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,327,900.00	21,324,839.00	3,061.00	100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	210,927,900.00	210,927,900.00	0.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,762,400.00	1,760,000.00	2,400.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,160,839,900.00	2,160,839,900.00	0.00	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,160,839,900.00	2,160,839,900.00	0.00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,160,839,900.00	2,160,839,900.00	0.00	100
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55.00	54.00	1.00	0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	0
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	45.00	1.00	0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	0.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,773,860.00	265,797,258.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,773,860.00	265,797,258.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,773,860.00	265,797,258.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,773,860.00	265,797,258.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,773,860.00	265,797,258.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	100,773,860.00	265,797,258.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,773,860.00	265,797,258.20

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,773,860.00	265,797,258.20
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан уялдаатай цогц бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангах зорилготой тус байгууллага нь төрийн захиргааны 25, төрийн үйлчилгээний 29, нийт 54 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Э.Энхтөр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Эрдэнэбилэг нар зурж, нярав Л.Батзориг ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- Сангийн сайдын 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-ийн стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 994,598.8 мянган төгрөгөөр буюу 59.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	15,480.0	15,480.0
Авлага	-	-	-
Бараа материал	14,541.2	19,463.4	4,922.2
Үндсэн хөрөнгө	1,466,291.6	2,440,488.2	974,196.6
Хуримтлагдсан элэгдэл	(50,574.4)	(76,150.6)	(25,576.2)
Нийт хөрөнгө	1,480,832.8	2,475,431.5	994,598.8
Өр төлбөр	0,0	0,0	0,0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,480,832.8	2,475,431.5	994,598.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,480,832.8	2,475,431.5	994,598.8

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансад нь 15,480.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь 2024 он санхүүгийн тайлангийн жилд авлага, өглөггүй байна.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 4,922.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 19,462.4 (бичиг хэрэг, аж ахуйн материалын үлдэгдэл) мянган төгрөг болсон нь тус байгууллагын холбогдох материалын нөөц бүрдүүлэлтэнд ач холбогдолтой байна.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан” байгуулан ажиллуулах журмыг үндэслэн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/65 дугаар тушаалаар “Ахмадын сан” байгуулсан байна. Ахмадын санд тайлант онд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын цалингийн сангийн хэмнэлтээс 3,700.0 мянган төгрөгийг, байр ашиглалтын зардлаас 3,620.0 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлын хэмнэлтээс 360.0 мянган төгрөгийг, тус газрын харъяа Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн цалингийн сангийн хэмнэлтээс 7,700.0 мянган төгрөгийг нийт 15,480.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, “Ахмадын сан”-ийн 2024 оны дансны үлдэгдэл 15,480.0 мянган төгрөг байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үндсэн хөрөнгө өмнөх оноос 974,196.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилийн зардлаас 14,588.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ХХҮЕГ-ын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/310 тушаал, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дугаар тушаалаар 102,039,2 мянган төгрөгний машин тоног төхөөрөмж шилжүүлэн авсан,

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 385 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын даргын 2024.04.03-ны өдрийн 25 дугаар захирамж, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дугаар тушаалаар 1,016,018.4 мянган төгрөгний Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, шугам сүлжээ шилжүүлэн авсан, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 25 дугаар захирамж, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дугаар тушаалаар 785,4 мянган төгрөгний машин тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/64 дугаар тушаалаар 1,440.0 мянган төгрөгний тавилга, эд хогшил, 450.0 мянган төгрөгний машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 979,118.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн, өмнөх үеийн үр дүн дансанд өөрчлөлт орж, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,459,951.5 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Улсын төсвөөс 1,871,162.5 мянга, нийт зарлагыг 1,871,162.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас санхүүжилтийг 214,662.4 мянган төгрөгөөр бууруулж, 1,656,500.1 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардлыг 125,708.6

мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардлыг 88,953.8 мянган төгрөгөөр хасч баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг 2024 оны 10 дугаар сард 380,091.9 мянган төгрөгөөр, 12 дугаар сард 12,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тодотгож, 2,160,839.9 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, хангамж, бараа материалын зардал, томилолтын зардлуудыг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Улсын төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,160,777.7 мянган төгрөг буюу нийт 99.9 хувьтай байсан, оны эцэст зардлын хэмнэлтийн 62,1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,926,821.7	1,926,821.7	-	100.0
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	234,018.2	234,018.2	-	100.0
	дүн	2,160,839.9	2,160,839.9		100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчигээний газрын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Хөдөлмөр, халамж үйлчилгээний Ерөнхий газраас 67,907.4 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 197,402.7 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 490.0 мянган төгрөг, нийт 265,797.2 мянган төгрөгийн орлого орсныг 67,904.7 мянган төгрөгийг амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн сургалт, өрхийн мэдээллийн сангийн нэгдсэн судалгааны зардалд, 53,402.7 мянган төгрөгийг төрийн албан хаагчдын орон нутгийн 10%-ийн нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэл, 135,000.0 мянган төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардалд, 8,000.0 мянган төгрөгийг 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээний шагналд, 1,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Залуучуудын хөгжлийн төвөөс хамтран зохион байгуулсан “Нэг хамт олон Нэг сайн дурын ажил” аяны 1 дүгээр байрын шагналд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 73,401.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,886.5 мянга, цэвэр бохир усны зардалд 8,102.4 мянган төгрөг батлагдсанаас “Хөвших-Од” ХХК-тай дулаанаар хангах гэрээ “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань-Баянхонгор” ХХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэбулган гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 721 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 2,160,839.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,608.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 14,045.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна. УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартыг хэрэгжүүлсэн байна. Эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөвлөмж, акт, албан шаардлага байхгүй.

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд санхүүгийн тайлангийн түүвэрт

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Алдааны товч утга	Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл						/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тайлагнаагүйг залруулав.	1	15,480.0					1	15,480.0		
Дүн	1	15,480.0					1	15,480.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.